



**СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2022 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

**Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар
2022 он**

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН АУДИТ

1. Аудитын нэр

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажуулсан.

3. Аудитын зорилго

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/29 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, зарим нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн сонгуулийн 5 сумын 5 тойрогт нэг намаас болон бие даан нэр дэвшсэн нийт 7 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна. Үүнд:

Хүснэгт-1

| | НЭРС | НАМ | НЭР ДЭВШИГЧИД |
|-----------|----------------------|------------|----------------------|
| Дд | | | |
| 1 | Монгол Ардын нам | 1 | 5 |
| 2 | Бие даан нэр дэвшигч | | 2 |
| | ДҮН | 1 | 7 |

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хороо

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 7 нэр дэвшигчдийн дансанд нийт 5.7 сая төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 5.7 сая төгрөг зарцуулж, харилцах дансанд 0 төгрөгийн үлдэгдэлтэй, 0.3 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаасан байна.

Сонгуульд нэр дэвшигчдэд 1 хуулийн этгээд 2.2 сая төгрөгийн мөнгөн бус хандив, 10 иргэн 3.5 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/21 дугаар тушаалаар “Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээ”-г тухайн тойргоос хамааран 10.6 сая төгрөгөөс 35.2 сая төгрөгийн хооронд байхаар тогтоосныг хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 7 нэр дэвшигч байна. Хугацаа хоцроосон, тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигч байхгүй байна.

Хуулийн хугацаандаа ирүүлсэн 7 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан бүгд аудитын хуулийн этгээдээр баталгаажсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 7 нэр дэвшигч, бүртгүүлээгүй нэр дэвшигч байхгүй байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 5.7 сая төгрөгийн 3.5 сая төгрөг нь мөнгөн, 2.2 сая төгрөг нь мөнгөн бус хандив байна. Үүнд:

Хүснэгт-2

| ОРЛОГЫН ТӨРӨЛ | ОРЛОГО | |
|-------------------------------|-----------|------------------------|
| | Тоо | /сая төгрөг/ Мөнгөн |
| Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө | 4 | 0.004 |
| Хуулийн этгээдийн хандив | 1 | 2.228 |
| Иргэний хандив | 10 | 3.445 |
| ДҮН | 14 | 5.677 |

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн хандивын зардлын тайлан

Нэр дэвшигчид нөхөн сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 5.7 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн үйл ажиллагааны зардалд 3.4 сая, сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардалд 2.2 сая, бусад зардалд 0.1 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт-3

| ЗАРДЛЫН АНГИЛАЛ | | МӨНГӨН ДҮН |
|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------|--------------|
| | | /сая төгрөг/ |
| НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | | 5.677 |
| 2.1 | Сонгуулийн зардлын дүн | 5.675 |
| 2.1.1 | Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах | 2.228 |
| 2.1.2 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах | 0 |
| 2.1.3 | намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал | 0 |
| 2.1.4 | сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал | 0 |
| 2.1.5 | сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал | 3.447 |
| 2.1.6 | сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал | 0 |
| 2.1.7 | цахим орчин ашиглах зардал | 0 |
| 2.1.8 | өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал | 0 |
| 2.2 | Бусад зардлын дүн | 0.002 |

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн хандивын зардлын тайлан

Нэр дэвшигчдийн зардлын тайлангууд өр төлбөргүй тайлагнасан байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай 5 иргэний 0.3 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөгүй хандив тайлагнаснаас 5 иргэний 0.3 сая төгрөгийн хандивыг буцаасан, хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг зарцуулсан нэр дэвшигч байхгүй байна.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлэхээс 7 нэр дэвшигчдийн дансны хуулгыг Хаан, Төрийн банкнууд ирүүлээгүй байна.

Аудитын дүгнэлт

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нам болон бие даан нэр дэвшсэн 7 дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн дүгнэлтийг аудитын хуулийн этгээд гаргасан байна.

10. Зөвлөмж

Сумдын Хаан, Төрийн банкны салбарын эрхлэгч нарт:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг цаашид хэрэгжүүлж ажиллах.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/21

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг олон нийтэд мэдээлэхийг аудитын гуравдугаар баг (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Хонгорзул)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт

/төгрөг/

| № | Тойрог | Тойргийн дугаар | Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр | Нэр дэвшигчийн | | Тайланг хугацаандаа ирүүлсэн эсэх | | Банкны нэр, дансны дугаар мэдэгдсэн эсэх | | Нийт орлого | Үүнээс: | | | | |
|-------------|-----------------|-----------------|---------------------------------|----------------|-------------|-----------------------------------|----------|------------------------------------------|----------|------------------|----------------|----------------|------------------|----------------|------------------|
| | | | | Овог | Нэр | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | | Өөрийн хөрөнгө | Хандив /орлого | | | |
| | | | | | | | | | | | | Иргэн | Мөнгөн дүн | Хуулийн этгээд | Мөнгөн дүн |
| 1 | Баян-Овоо сум | 1 | Монгол ардын нам | Цэдэнбалжир | Бямбадэлгэр | 1 | - | 1 | - | 200 | 200 | - | - | - | - |
| 2 | Булган сум | 3 | Монгол ардын нам | Найдансүрэн | Амаржаргал | 1 | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| 3 | Булган сум | 3 | Бие даан нэр дэвшигч | Сумъяадорж | Өлзийдүүрэн | 1 | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| 4 | Даланзадгад сум | 3 | Монгол ардын нам | Жамсран | Сайнжаргал | 1 | - | 1 | - | 3,230,000 | 2,000 | 1 | 1,000,000 | 1 | 2,228,000 |
| 5 | Даланзадгад сум | 3 | Бие даан нэр дэвшигч | Дашжамц | Баянмөнх | 1 | - | 1 | - | 2,445,000 | - | 9 | 2,445,000 | - | - |
| 6 | Мандал-Овоо сум | 3 | Монгол ардын нам | Банзрагч | Мөнгөншагай | 1 | - | 1 | - | 1,000 | 1,000 | - | - | - | - |
| 7 | Номгон сум | 1 | Монгол ардын нам | Гомбодаш | Энхбилэг | 1 | - | 1 | - | 1,000 | 1,000 | - | - | - | - |
| Нийт | | | | | | 7 | - | 7 | - | 5,677,200 | 4,200 | 10 | 3,445,000 | 1 | 2,228,000 |

Хавсралт 2

Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт

/төгрөг/

| № | Тойрог | Тойргийн дугаар | Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр | Нэр дэвшигчийн | | Нийт зардал | Үүнээс: | | | | | | | | |
|------------|-----------------|-----------------|---------------------------------|----------------|-------------|------------------|-----------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|---------------------------------------------------|-------------------------------------------------------|---------------------------------------------------|----------------------------|------------------------------------------------------------------|-------------------|
| | | | | Овог | Нэр | | Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагтамбар, дэлгэц байрлуулах | Намын далбагудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал | Сонгогчид той уулзалт, хурал, цуглаан хийх зардал | Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал | Сонгуулийн сурталч илгаанд радио, телевиз ашиглах | Цахим орчин ашиглах зардал | Өдөртутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал | Бусад зардлын дүн |
| 1 | Баян-Овоо сум | 1 | Монгол ардын нам | Цэдэнбалжир | Бямбадэлгэр | 200 | - | - | - | - | - | - | - | - | 200 |
| 2 | Булган сум | 3 | Монгол ардын нам | Найдансүрэн | Амаржаргал | | - | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Булган сум | 3 | Бие даан нэр дэвшигч | Сумъяадорж | Өлзийдүүрэн | | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Даланзадгад сум | 3 | Монгол ардын нам | Жамсран | Сайнжаргал | 3,230,000 | 2,228,000 | - | - | - | 1,002,000 | - | - | - | - |
| 5 | Даланзадгад сум | 3 | Бие даан нэр дэвшигч | Дашжамц | Баянмөнх | 2,445,000 | - | - | - | - | 2,445,000 | - | - | - | - |
| 6 | Мандал-Овоо сум | 3 | Монгол ардын нам | Банзрагч | Мөнгөншагай | 1,000 | - | - | - | - | - | - | - | - | 1,000 |
| 7 | Номгон сум | 1 | Монгол ардын нам | Гомбодаш | Энхбилэг | 1,000 | - | - | - | - | - | - | - | - | 1,000 |
| ДҮН | | | | | | 5,677,200 | 2,228,000 | - | - | - | 3,447,000 | - | - | - | 2,200 |

Хавсралт 3**Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд****/төгрөг/**

| № | Тойрог | Тойргийн дугаар | Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр | Нэр дэвшигчийн | | Хандив өгсөн | |
|---|-----------------|-----------------|---------------------------------|----------------|------------|----------------------------|------------|
| | | | | Овог | Нэр | Иргэний нэр | Мөнгөн дүн |
| 1 | Даланзадгад сум | 3 | Монгол ардын нам | Жамсран | Сайнжаргал | Т.Алтансүх | 1,000,000 |
| 2 | Даланзадгад сум | 3 | Монгол ардын нам | Жамсран | Сайнжаргал | Өмнөговь аймгийн МАН хороо | 2,228,000 |
| 3 | Даланзадгад сум | 3 | Бие даан нэр дэвшигч | Дашжамц | Баянмөнх | А.Азжаргал | 2,000,000 |